



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 354

Улаанбаатар хот

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ”
төрийн өмчит хувьцаат компанийн
2018 оны төлөвлөгөөнд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 675 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хавсралтад заасан төсөл, арга хэмжээг нэмсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 675 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний их засвар хэсгийн 29-д “HINO автокраны мотор солих /бүрэн ээлж хийх/” гэснийг “DAEWOO урт ачааны машины мотор солих” гэж, хөрөнгө оруулалт хэсгийн 6-д “Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн барилга /Эрдэнэт/” гэснийг “Аж ахуйн хашаанд склад барих” гэж, 13-д “Цогц програм хангамж” гэснийг “Компьютер, хэвлэх төхөөрөмж” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 675 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хөрөнгө оруулалт хэсгийн 1-д заасан “33 хүний суудалтай” гэснийг хассугай.

4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 675 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн 14-д “Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-6,733.7 сая төгрөг” гэснийг “Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-7,367.9 сая төгрөг” гэж өөрчилсүгэй.

0002135


5.Компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан компанийн 2018 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авалтын төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд даалгасугай.

6.Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Г.Баярцогтод даалгасугай.

7.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн
 354 дугаар тогтоолын хавсралт



“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ”
 төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны
 техник зохион байгуулалтын арга хэмжээ,
 хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд
 нэмж тусгах төсөл, арга хэмжээ

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төсөвт өртөг /мян.төг/
ТЕХНИК ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ				
Булган салбар				
1	Хөвсгөл аймгийн Тариалан сумын Хужиртын зоогийн газрын 10 кВ-ын ЦДАШ, 50 кВА дэд станц барих	ком	1	32 000,0
2	Хөвсгөл аймгийн Тариалан сумын сүү боловсруулах үйлдвэрийн 10 кВ-ын ЦДАШ, 250 кВА дэд станц барих	ком	1	17 900,0
3	Архангай аймгийн Эрдэнэмандал суманд байрлах Мод модон эдлэлийн үйлдвэрлэл, худалдааны төв 10 кВ-ын ЦДАШ, 100 кВА дэд станц барих	ком	1	25 600,0
4	Булган аймгийн Булган сумын 1-р баг Байшинт, Малчны хороонд мал бүхий иргэдийг цахилгаан эрчим хүчээр хангах	ком	1	95 000,0
Архангай салбар				
5	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шаардлагын дагуу 35/10 кВ-ын дэд станцуудад камержуулалт тавих	ком	1	50 000,0
Хархорин салбар				
6	Төв аймгийн Бүрэн сумын Хайрхан хорооллын айл өрхийн цахилгаан хангамжийг сайжруулах	ком	1	130 000,0
Техник зохион байгуулалтын арга хэмжээний нийт дүн				350 500,0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
1	Аваарын нөөцийн зайлшгүй шаардлагатай сэлбэг материал	ком	1	283 750,0
Хөрөнгө оруулалтын ажлын дүн				283 750,0
НИЙТ ДҮН				634 250,0